

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

НЭРТ ЗУРААЧ СЮЙ БЭЙХУН

(Төрсний нь 90 жилийн ойд)

Хятадын шинэ үеийн уран зургийн хөгжлийг үндэслэгчдийн нэг нэрт зураач Сюй Бэйхуны төрсний 90 жилийн ойд Хятадын ард түмэн дэлхийн дэвшилт олон нийтийн хамт саяхан ёслон тэмдэглэв.

Энх тайвны хөдөлгөөний гарамгай зүтгэлтэн, Хятадын орчин үеийн зургийн урлагийн үндсийг тавигч Сюй Бэйхун 1895 оны 5-р сарын 19-нү Цзяньсу мужийн нэг хошуунд ядуу зураачийн гэр бүлд төржээ.

Сюй Бэйхуны нэрийг сонссон хэн бүхний боловч нүдэнд түүний бүтээсэн гайхамшигт морьд, байгалийн үзэсгэлэн гоог магтан дуулсан зургууд, түүхэн баатарлаг хүмүүсийн дүр өөрийн эрхгүй бууна.

Бяцхан Бэйхуны анхны багш нь түүний эцэг байв. Эцэг Сюй Дачжан нь Хятадын эртний түүх, уран зохиолыг сайн мэддэг, зургийн “гохуа”¹ төрлийг гойд эзэмшсэн хүн байлаа. Эцгийн нь зургийн авьяас, хөдөлмөрч хичээнгүй байдал Бэйхунд уламжлагдан үлдсэн байна.

Сюй Бэйхуны бага залуу нас амьдралын хүнд нөхцөлд өнгөрчээ. Тэр 16 настайда эцгээсээ хагацаж, гэрийнхнийгээ тэжээх амаргүй үүрэг залуу хүүд ноогджээ. Тэрээр гэрийнхнийгээ тэжээхийн тулд хар ажил туйлдатлаа хийдэг байсан боловч уран зургаа орхисонгүй. Төрөлх нутгийнхаа байгалийн байдал, хөдөө нутгийн амьдралыг харуулсан зургийг тэр олноор зурдаг байлаа.

Сюй Бэйхун 19 настайдаа гэрээсээ холдон олон газар нутгаар явж их юм үзжээ. Ингэж явахдаа хэлэн дээрээ юу ч тавилгүй хоосон өнждөг үе ч түүнд цөөнгүй байжээ. Тэр өлсөхийн эрхэнд нэг удаа морь зурж “Шэньмэй” хэвлэлийн газар илгээжээ. Тэр үед энэ хэвлэлийн газрыг нэрт зураач Гас Цзянфу, Гао Цифэн² нар хариуцдаг байв. Бэйхун удалгүй тэднээс зургийн үнэ, мөн өндөр үнэлэлт бүхий хариу хүлээн авлаа. Ирүүлсэн захианд нь “...зурсан зураг чинь Хань Ганий³ бүтээлүүдээс ч дутахааргүй байна...” гэж магтаал дахин 4 зургийн захиас өгчээ. Хожим нь энэ захиасыг ямар их хүч хөдөлмөр, тэвчээр гаргаж биелүүлсэн тухай Ляо Цзинвэний “Сюй Бэйхуны амьдрал, миний дурдатгалаас”⁴ номонд: “...өглөөд өлөн ходоодоо хонхолзуулан гудамжинд гарахад хоолны үнэр ханхалж, тэр сайхан үнэрээс болж

¹ “гохуа” –Хятадын үндэсний зургийн арга. Бэх, байгалийн будгаар тусгай бэлтгэсэн торгон болон цаасан хуйлмал дээр бийрээр зурахыг хэлнэ.

² Гао Цзяйфу (1881-1951). Гао Цифэн (1889-1933) нар үндэсний уламжлалт зургийн аргад европ маягийг хэрэглэх санааг анх дэвшүүлжээ. Тэдгээрийг залгамжлагчдыг “линнаний” сургуулийнхан гэж нэрлэдэг байв.

³ Хань Гань-морины зургуудаар нэрд гарсан уран зураач (VIII зуун)

⁴ Ляо Цзиньвэнь-Сюй Бэйхуны эхнэр

толгой эргэнэ. Үргэлжийн өлсгөлөнгөөс болж өдөр хоног уяатай мэт удаан үргэлжилнэ. Зургаа зурахаар бийрээ барьсан Бэйхуны нүд харанхуйлж ухаан балартдаг үе ч цөөнгүй байв. ..." гэж бичжээ.⁵

Сюй Бэйхун амьдралынхаа турш зөвхөн морины гэхэд л 1000-аад зураг зуржээ.⁶ Түүний бүтээсэн тал хөндийгөөр дэлээ намируулан дөрвөн туурай нь газар хүрнэ үү үгүй юу гэмээр хамаг эрчээрээ агаар зүсэн хурдлан давхих хүлэг морьд эрх чөлөө, ирээдүйн сайн сайхны төлөө тэмүүлэгч Хятадын ард түмний хязгааргүй хүсэл эрмэлзлэлийн билэг тэмдэг болсон юм.

Сюй Бэйхун 21 настайдаа Чиндэний их сургуулийн франц хэлний ангид элсэн оров. Энэ нь хожим Парист зургийн ур чадвараа улам дээшлүүлэхэд их тус болжээ. Тэрээр 1919 онд эхлээд зургийн Жюльени академид, дараа нь Парисын сонгодог урлагийн дээд сургуулийн зургийн ангид элсэн нэрт зураач Фламэнд⁷ шавь оржээ. Багш нь алс холын орноос ирсэн хичээнгүй оролдлоготой, авьяаслаг шавьдаа их хайртай байлаа. Сюй Бэйхуны уран бүтээлд хүчтэй нөлөө үзүүлсэн бас нэг хүн бол Даньян-Бувре⁸ билээ. Тэрээр залуу хүүд: "аливаа зургийг зурахын тулд гурван удаа давтан зурах шаардлагатай. Анхны зургаа зурчихаад дараа нь эх зургаа харалгүй цээжээрээ хоёр дахь удаагаа зурна. Эцэст нь анхны эх дээрээ засвар хийх хэрэгтэй бөгөөд ингэж хөдөлмөрлөж байж амжилтанд хүрч болно..." хэмээн сургадаг байв.⁹

Сюй бэйхун суралцах хугацаандаа дэлхийн сонгодог урлагуудтай танилцан зарим эхээс уйгагүй хуулбар хийж, зургийн утга техникээс хичээнгүйлэн суралцдаг байжээ. 1924 оноос эхлэн түүний зургууд Парисын үзэсгэлэнгүүдэд тавигдан олны сайшаалыг хүртэх болов.

1927 онд Сюй Бэйхун сургуулиа төгсөөд эх орондоо буцжээ. Өгүүлэн буй үеийн Хятадын нийгэм-улс төрийн амьдрал нэлээд хурцадмал байдалтай байлаа. Гадаадын колоничлолд талхигдан сүйрсэн Хятад оронд уран зураг, соёлын амьдралын хэрэгцээг хангахгүй байв. Зураач нарын нийгэм дэх үүрэг роль багасч, тэд улс орныхоо дотор болж байгаа амьдралаас хол тасархай амьдарч байлаа.

Урьд үеийнхээ болон тэр үеийн зураачдаас Сюй Бэйхуны ялгаатай тал нь Хятадын уран зургийн хөгжлийг шинэ шатанд гаргасанд оршино. Сюй Бэйхун дэлхийн олон сая хүмүүст анх удаа Хятадын ард түмний амьдрал, ер нь Хятад орны тухай нийтэд ойлгомжтой хэлээр хэлж өгсөн анхны зураачдын нэг билээ.

Тэр Парисаас ирсний дараа олон жил багшийн ажил хийжээ. Тэрээр Шанхайн зургийн институт Нанкины их сургуульд ээлжлэн багшилж байв. Хожим нь БНХАУ-ын зургийн академийн ерөнхийлөгчөөр, Хятадын мэргэжлийн зураачдын нэгдлийн даргаар тус тус томилогдон ажиллаж байв.

Багшлах хугацаандаа Хятадын зургийн урлагийн ягшмал тогтсон үеэ өнгөрөөсөн, хуучин дүрэм горимыг реалист аргаар солих, үндэсний зургийн төрөл "гохуа"-г Европын зургийн шилдэг аргатай хослуулсан шинэ аргыг бий болгох, тэрчлэн залуу үеийнхнийг өрнөдийн соёлын өвтэй танилцуулж, түүнээс бүтээлчээр сурахад нь бүхий л хүч чадал, авьяас билгээ тэр дайчлан ажиллаж байлаа.

⁵ "Проблемы Дальнего Востока" 1984. № 4, стр 151.

⁶ "Жили шандэ байкэ жиши 366 тянь ("Хуанлийн 366 өдрийн лавлах") Бээжин. 1983 253-р тал (хятад хэл дээр)

⁷ Фламэн-Парисын яруу урлагийн дээд сургуулийн захирал

⁸ Даньян Бувре –тэр үеийн францын нэрт зураач

⁹ "Проблемы Дальнего Востока" 1984. № 4, стр 156.

Сюй Бэйхун дэлхийн олон орны ард түмэн харилцан бие биенээ ойлгох, түүнчлэн олон улсын хамтын ажиллагаа болон соёлын хөгжилд уран зураг чухал үүрэгтэй болохыг ямагт үнэлэн үздэг байлаа. Хятадын зургийн үзэсгэлэнг Европын орнуудад нээн ажиллуулах тухай түүний саналын дагуу 1933 оны 1-р сараас Хятадын анхны зургийн үзэсгэлэнг европын олон оронд гаргажээ.

Нутагтаа эргэж ирсний дараа Сюй Бэйхун Нанкины их сургуулиас ЗХУ, Хятадын хооронд зураач, барималчдын бүтээлүүдээс солилцож байх тухай шийдвэрийг санаачилжээ. Энэ шийдвэрийн ач холбогдлыг Зөвлөлтийн зураачдын холбооноос үнэлэн"... ЗХУ-д гадаадын уран зургийн олон үзэсгэлэн ирж ажиллаж байсан боловч Хятадын зургийн үзэсгэлэн шиг манай үзэгчдээс өндөр үнэлэлт авч байсан үзэсгэлэн байхгүй юм. Уран зургийн бүтээлүүдээ солилцох нь зөвлөлт, Хятадын соёлын зүтгэлтнүүдийн хоорондох хамтын ажиллагаа цаашид өргөжихийн үндэс суурь болох ёстой...."¹⁰ гэжээ.

1935 онд Сюй Бэйхуны санаачилгаар Хятад-Зөвлөлтийн соёлоор харилцах нийгэмлэг байгуулагдав. Сюй Бэйхун Хятадын ард түмэн зөвхөн Зөвлөлтийн соёл урлаг төдийгүй социализмын ууган орны энх тайванч гадаад бодлого, ард түмнийх нь бүтээн байгуулах их үйлсдээ олж байсан амжилтаас тэр үеийн мөрдлөгө мөшгөлтөөс үл айн сурталчилж байжээ. 1948 онд бичсэн нэгэн дурсамжиндаа: ЗХУ-д байхад төрсөн миний хамгийн хүчтэй сэтгэгдэл бол энэ оронд ажилгүйдэл байдаггүй учраас ажилгүй зураач гэж алга. Би европ, азийн хаана ч ийм байдлыг хараагүй юм..."¹¹ гэжээ.

Соёлын хувьсгалын үед нийгмийн хөгжил дэвшлийн төлөө цогтой тэмцэгч Сюй Бэйхуны бүтээлүүд улаан хамгаалагчдын гарт үрэгдэн, түүний дурсгалд зориулсан музейг ямар ч ул мөргүй болтол нь эвдэн сүйтгэжээ. Гэвч ард түмнийхээ хайрыг булаасан авьяаслаг зураачийн нэр алдар, гавьяа зүтгэлийг нь үгүйсгэж чадаагүй юм. Түүний нэрийг зөвхөн Хятад орны хүрээнд төдийгүй гадаадын олон орон түүний дотор манай монголын ард түмэнд маш ойр дотно байдаг юм.

XX зууны Хятадын нэрт зураач Сюй Бэйхуны нас нөгчсөний 30 жилд зориулсан үзэсгэлэнг 1983 оны 9-р сард ЗХУ-ын Дорнодахины ардын урлагийн музейд нээн ажиллуулав. Үзэсгэлэнд Сюй Бэйхуны ардын "Уд модон дээрх шаазгай (1936)", "Хулсны дэргэдэх тахиа" (1944), "Усан дээр" (1943), "Үхэлгүйн арал", "Дайны талбар дахь бодол", "Аргамаг хүлэг" (1947), "Наранцэцэг ба тахиа" (1936) зэрэг нийт 15 бүтээл тавьжээ.¹² энэ нь Сюй Бэйхун зөвлөлтийн ард түмэнд хичнээн нэр хүндтэй байдгийн нэг илрэл юм.

Уран зураачдад зөвхөн эцэг эхээс заяасан төрөлхийн авьяас билгээс гадна нөр хичээнгүй хөдөлмөрч зан, аливаа бэрхшээлийг даван туулж чадах тэсвэр хатуужил, амьдралын үнэнийг олж харах билгийн нүд, амьдралаас ухаарсан зүйлээ үнэн сэтгэлээсээ мэдэрч бүтээж туурвиж чаддаг чадвар зэрэг олон онцлог чанар байж тэдгээрийг бүрэн эзэмшиж баймааж нь сая хүмүүсийн сэтгэл зүрхэнд хоногшихуйц,

¹⁰ Хуан мяоцы "Сюй Бэйхун". Бээжин. 1957. 14-р тал (хятад хэл дээр)

¹¹ "Проблемы Дальнего Востока" 1979. № 1. Стр 179.

¹² "Проблемы Дальнего Востока" 1984. № 3. Стр 127.

олон үед дамжин дуурсагдахуйц бүтээл туурвиж чадна. Эдгээр чанарыг гүйцэд эзэмшсэн зураачийн нэг нь Сүй Бэйхун билээ. Өөрийн бүтээлээрээ соёлт хүмүүсийн дунд нэрд гарсан Хятадын их зураач нь улс түмнүүдийн хооронд найрамдалт харилцааг бэхжүүлэхэд болон зөвлөлт нийгмийн мөн чанарыг бодитойгоор үнэлэн үзэж, ард түмэндээ сурталчлах их үйлсэд багагүй хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэг билээ.

Л.Лхамдулам